

**“БИЗНЕСС КАП 2024”/ BUSINESS CUP 2024
ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

НЭГ. ЗОРИЛГО

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нийтийн хөлбөмбөг” хөтөлбөрийн “Хамтын ажиллагаа, түншлэл” дэд хөтөлбөрийн хүрээнд хөлбөмбөгөөр дамжуулан олон улсад үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хөлбөмбөгийн спортыг дэмжих үйл ажиллагааг эхлүүлэх,
2. Хөлбөмбөгийн спортоор дамжуулан бизнесийн байгууллагуудын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, нийтийн биеийн тамирын хүрээнд эрүүл чийрэг болгох, Европын Аварга Шалгаруулах Тэмцээнтэй уялдуулан, байгууллагуудын хөлбөмбөгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, байгууллага бүрийг хөлбөмбөгийн багтай болгох, багийг бүрдүүлэх,
3. Хөлбөмбөгийн спортоор дамжуулж харилцаа холбоо, уялдааг сайжруулах,

ХОЁР. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Тэмцээнийг МҮХАҮТ болон МХБХолбооноос хамтарсан тэмцээн зохион байгуулах комисс зохион байгуулна.
2. Тэмцээнд зөвхөн МҮХАҮТ-нд бүртгэлтэй гишүүнчлэлтэй байгууллага оролцоно.
3. Тэмцээнд байгууллага төлөөлж, 2024.01.01-ний өдрөөс өмнө ажилд орж хөдөлмөрийн гэрээ байгуулсан тоглогч байх ба НДШ төлдөг байх шаардлагатай.
4. **Тэмцээнд** төрсөн он сар өдрөөр 18 наснаас дээш насны тоглогч оролцоно.
5. Тэмцээнд нийт 24 баг оролцох бөгөөд Европын Аварга Шалгаруулах Тэмцээний оноолтын дагуу явагдана. Эхэнд бүртгүүлсэн 24 багийг Евро-2024 тэмцээнд оролцож байгаа орнуудын нэрээр сугалуулан оролцуулна.

Үүнд:

А хэсэг

A1 Герман
A2 Шотланд
A3 Унгар
A4 Швейцар

С хэсэг

C1 Словени
C2 Дани
C3 Серби
C4 Англи

Е хэсэг

E1 Бельги
E2 Словак
E3 Румын
E4 Украйн

В хэсэг

B1 Испани
B2 Хорват
B3 Итали
B4 Албани

Д хэсэг

D1 Польш
D2 Недерланд
D3 Австри
D4 Франц

F хэсэг

F1 Турк
F2 Гүрж
F3 Португал
F4 Чех

6. Тэмцээн нь 2024.05.25-ны өдрөөс 06.15-ны өдрийн хооронд зохион байгуулагдана.
7. Тоглолт бүр ОУХБХ-ны Шилдэг бүтээн байгуулалт болсон МХБХ-ны Шигшээ багийн AirDome бэлтгэлийн төвд зохион байгуулагдана.
8. Тэмцээнд оролцох эрхийн төлбөр: 2.000.000 /Хоёр сая/ төгрөг байна. Төлбөрийг МҮХАҮТ-ын Хаан банкны 5112170005 тоот дансанд Техникийн зөвлөгөөн болохоос 3 хоногийн өмнө шилжүүлнэ. Багийн бүрэлдэхүүн 1 дасгалжуулагч болон 18 тоглогч байна.
9. Багт тухайн байгууллагын ажилтан мэргэжлийн тамирчин 1 байхыг зөвшөөрнө. Мэргэжлийн тамирчин гэдэг нь 2024 онд МХБХ-ны Талбайн Дээд болон 1-р лиг, Футзалын Дээд лигт бүртгэлтэй тамирчинг тооцно.
10. Тоглолтын дундуур гурван оролдлогоор 5 сэлгээ хийх боломжтой. Үе хооронд хийсэн сэлгээг оролдлого хийсэн гэж үзэхгүй.
11. Тэмцээний зөвлөгөөн МҮХАҮТ-ын 503 тоот өрөөнд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 14:00 цагт болно. Багууд тэмцээнд оролцоход дараах материалуудыг бүрдүүлнэ:
 - 11.1 Багийн мэдүүлэг
 - 11.2 Тоглогчдын иргэний үнэмлэх
 - 11.3 Тоглогчдын Нийгмийн даатгал төлсөн баримт
 - 11.4 Тэмцээний такс төлсөн баримт

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ ЖУРАМ

1. Уг тэмцээн нь МХБХ-ны ТЗБЖ-ын дагуу зохион байгуулагдана.
2. Зааварт тусгагдагүй зүйлс МХБХ-ны ТЗБЖ-ын дагуу зохицуулагдана.
3. Багууд өөрийн гэсэн хоёр ээлжийн иж бүрэн хувцастай байна.
4. Тэмцээнийг МХБХ-ны шүүгчдийн бүрэлдэхүүн шүүх бөгөөд шүүгчийн шийдвэр эцсийнх байна.
5. Багаас гарсан зүй бус үйлдэл сахилга баттай холбоотой асуудлыг тэмцээнийг зохион байгуулах комисс шийдэж, мөнгөн торгууль болон тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

1. Эхний 3 байранд орсон багуудад шагнал гардуулна.
 - a. I байр - Шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл 10,000,000 төгрөг
 - b. II байр - Мөнгөн медаль, өргөмжлөл, 8,000,000 төгрөг
 - c. III байр - Хүрэл медаль, өргөмжлөл 6,000,000 төгрөг
2. Шилдэг довтлогч, хагас хамгаалагч, хамгаалагч, хаалгач нарыг тодруулан тус бүр 500,000 төгрөгөөр тус тус шагнана.